



WORLD BANK GROUP

Монгол Улс

Эдийн засгийн сүүлийн үеийн
өөрчлөлтүүд болон
тулгамдсан асуудлууд


2014 оны 7-р сар

Эдийн засгийн сүүлийн үеийн өөрчлөлтүүд

Уул уурхайн бус салбарын үйл ажиллагаа суларсантай холбоотойгоор эдийн засгийн өсөлт удааширч байна.


2014 оны эхний улиралд өсөлт цаашид 7.4 хувь хүрч зөөлрөв.

Улирлын уул уурхайн болон уул уурхайн бус салбарын бодит ДНБ-ний өсөлт (өмнөх оны мөн үетэй харьцуулбал, %)



Уул уурхайн салбар эерэг хэвээр байгаа ч дотоодын аж үйлдвэрлэл суларсаар байна.

Бодит ДНБ-ний өсөлтийн хувь салбараар (%)



Инфляци хоёр оронтой тоон түвшинд хэвээр байна.

5-р сард инфляци 13 гаруй хувь болон хурдассан байна.

Улсын инфляци ба суурь инфляци (%)



Сүүлийн үеийн хоёр оронтой тоон инфляци эрэлтийн дарамт өссөний улмаас бий болов.


Улсын инфляци ба Мөнгөний үзүүлэлт



Инфляци өндөр байгаа нь өрхийн худалдан авах чадвар болон дотоодын эрэлтэнд хүнд тусч байна.


Инфляцийн түвшин өрхийн нэрлэсэн орлогын өсөлтөөс хэтэрчээ.

Өрхийн орлогын өсөлт ба ХҮИ-н инфляци (%)




Хэрэглээний өсөлтийн хувь хэмжээ болон хөрөнгө оруулалт буурав.

Улирлын бодит ДНБ-ний өсөлт, зардлаар (%)




Гурван жилийн хугацаанд эдийн засгийн өсөлт өндөр байсан нь хүчтэй ГШХО-гүйгээр тогтворжуулах боломжгүй урсгал дансны алдагдал дагуулсаар ирсэн.

Урсгал дансны алдагдал 2011-2013 оны хоёр оронтой тоогоор хэмжигдэх өсөлтийн хугацаанд ДНБ-ний 30 гаруй % хүрч огцом өсчээ.



2011 оноос хойш импорт ихээхэн нэмэгдсэн нь урсгал дансны алдагдлыг огцом нэмэгдэхэд хүргэжээ.




ГШХО сүүлийн гурван жилийн хугацаанд урсгал дансны алдагдлыг санхүүжүүлсэн өсөлтийн гол хөдөлгөгч хүч байсан боловч 2013 ба 2014 онд буурсаар байна.


ГШХО нь 2013 онд тал хувиар буурав...

... улмаар 2014 онд үргэлжлүүлэн буурсаар байна.

Жилийн ГШХО-ын дотогшлох урсгал (ДНБ-д эзлэх %)




Сар тутмын ГШХО-ын хандлага (сая ам доллараар, 3 сарын гулсмал дундаж)



Төлбөрийн тэнцлийн тэнцвэргүй байдал их байгаа нь дотоодын мөнгөн тэмдэгтийн үнэ цэнэ, гадаад валютын нөөцөд дарамтыг бий болгож байна.

Урсгал дансны алдагдал ихэсч гадаад хөрөнгийн дотогшлох урсгал буурч байгаагаас гадаад санхүүжилтийн цоорхойг ихэсгэж байна.

Жилийн төлбөрийн тэнцэл (сая ам доллараар)




Үлмаар дотоодын мөнгөн тэмдэгтийн үнэ цэнэ суларч гадаад валютын нөөц буурсан.



Одоо урсгал дансны алдагдал багасч байна.


Урсгал данс багасч байна...

Сар бүрийн урсгал данс ба худалдааны тэнцэл (тэрбум ам доллараар)



...түүнчлэн импортыг багасгаж зэс, газрын тосны экспортыг сайжруулах замаар өөрчлөлт хийгдэж байна.

Өмнөх жилийн мөн үетэй харьцуулсан экспорт, импортын өсөлт (% , 3 сарын гулсмал дундаж)



Эдийн засгийн байдал ба тулгамдсан асуудлууд

Эдийн засгийн ихээхэн тэнцвэргүй байдлын улмаас 2014 онд эдийн засгийн өсөлт зөөлрөх хандлагатай байна.

Бодит ДНБ-ний өсөлт нэг тоон үзүүлэлтийн түвшинд хүрэхэд туслах нь бага байгаа ч бүсийн хэмжээний бусад орнууд дундаа хамаарлын хувьд хамгийн өндөр орон хэвээр байна.

- ОТ-н уурхайн зэсийн үйлдвэрлэл сэргэж үргэлжлэх болсны улмаас уул уурхайн салбарын ДНБ-ний огцом өсөлт үргэлжилнэ.

- Инфляци өндөр, төлбөрийн тэнцлийн дарамт ихтэй байгаас уул уурхайн бус салбарын гарц бүтээгдэхүүн дарамтанд хэвээр байх болно.

Удааширсан эдийн засгийн өсөлт нь эдийн засгийн өөрчлөлтөнд нөлөөлж инфляцийн түвшин өндөр, гадны санхүүжилтийн цоорхой их байгаад эдийн засгийн тодорхой хариу үйлдэл үзүүлэх хүлээлт бий болгож байна.

Төлбөрийн тэнцэлд ихээхэн дарамт бий болж, санхүүгийн салбарын үзүүлэлт суларч буй зэргээс эдийн засаг сөрөг эрсдэлтэй тулгараад байна.


Урсгал дансны алдагдлыг багасгаж байгаа боловч ГШХО буурч байгаа учраас төлбөрийн тэнцлийн алдагдал хэвээр байсаар байна.

Сар бүрийн гол төлбөрийн тэнцлийн хандлага (3 сарын гулсмал дундаж, тэрбум ам доллараар)



Бодлогын дэмжлэг үзүүлснээр зээлийн өсөлт хурдацтай байгаа ч найдваргүй зээл, хугацаа хэтэрсэн зээлийн тоо хурдацтай нэмэгдэж байна.


Найдваргүй ба хугацаа хэтэрсэн зээл (өм. оны мөн үетэй харьцуулсан өсөлт, %)



Орон сууцны зах зээлийн хурдацтай өсөлт хэт халах нөхцөл байдлыг бий болгож болзошгүй.


2013 онд барилга ба орон сууцны зах зээлд 2 их наяд төгрөгийн зээл олгожээ.

Барилга ба Орон сууцны зах зээлд арилжааны банкуудаас олгосон зээл



Өнгөрсөн гурван жилийн хугцаанд орон сууцны үнэ маш хурдацтай нэмэгдэж байна.


Орон сууцны үнийн индекс (2007=100)



Өрхийн өрийн хэмжээ нэмэгдэж байгаад маш нягт нарийн мониторинг хийх шаардлагатай.


Орон сууцны моргеж зээлийн өсөлтийн улмаас өрхийн зээлийн хэмжээ 50 гаруй хувиар нэмэгджээ.

Өрхүүд болон моргеж зээлэнд арилжааны банкуудаас олгосон зээл



Өрхийн жилийн орлого дахь өрхийн дундаж өр 2013 онд 60 орчим хувь болж өсчээ.


Өрхийн өр жилийн орлого ба ДНБ-ний харьцаа



Тэгвэл, юу хийх хэрэгтэй вэ?

Эдийн засгийн мөчлөгийг дагасан бодлого эдийн засгийн эмзэг байдлыг нэмэгдүүлж байна.

Макро эдийн засгийн гол үзүүлэлтүүд сүүлийн гурван жилийн хугацаанд эдийн засгийн бодлого нь эдийн засгийн мөчлөг дагасан бодлого байсныг харуулж байна.



2011-2012 онд ГШХО-ын дотогшлох урсгал давалгаалснаар эдийн засгийн өсөлт сайн байсан ...

ба ГШХО-ын түлхэцээр бий болж буй эдийн засгийн огцом өсөлтийг дэмжсэн эдийн засгийн бодлогууд цаашид (i) төсвийн алдагдлыг нэмэгдүүлж (ii) ГШХО-ын дотогшлох урсгалын давалгаагаар бий болсон зээлийн огцом өсөлтийг бий болсон.

2013 онд эдийн засгийн бодлогууд нь өсөлт удааширсан, ГШХО/уул уурхайн зах зээл суларч, төлбөрийн тэнцлийн тэнцвэргүй байдал ихэссэн зэрэг асуудлуудтай тулгарсан ...

бөгөөд төсвөөс гадуурх зардал, тоон хэмжээний сулруулалтыг ашиглан эдийн засгийн өсөлтийг дэмжих сонголт хийсэн.

→ Урсгал дансны алдагдал ГНБ-ний бараг 30% байсан нь хэвээр үлдэж 2013 онд инфляци хоёр оронтой тоогоор дахин илэрхийлэгдэв.

Эдийн засаг ба санхүүгийн тогтвортой байдлыг сэргээх нь яаралтай чухал байна.

Эдийн засгийн тогтвортой байдал гэдэг нь “дотоод, гадаад эдийн засгийн тэнцлийг хангах замаар өсөлтийг хоёр оронтой тоонд хадгалах” гэсэн үг үү?

- Өнөөгийн эдийн засгийн эмзэг байдал нь эдийн засгийн хэт халалтын үр дүнд бий болсон.

- Эдийн засгийн тогтвортой байдал гэдэг нь эдийн засгийн оновчтой бодлогоор үнийг тогтворжуулж, төлбөрийн тэнцлийн дарамтыг бууруулах гэсэн үг юм.

- Эдийн засгийн тогтвортой байдлыг хангаснаар ирээдүйд урт хугацааны турш хөгжин дэвших тогтвортой, тууштай замаар эдийн засаг өсөх нөхцлийг бүрдүүлнэ.

Эдийн засгийн бодлого нь өсөлтийг дэмжихээсээ илүү эдийн засаг санхүүгийн тогтвортой байдлыг бий болгох талруу бүтцийн хувьд шилжих хэрэгцээ байна.

- Мөнгөний болон төсөв санхүүгийн бодлогыг чангатгах
- Банкны салбарын эрүүл тогтвортой нөхцлийг хянах хяналтыг бэхжүүлэх.

Мөнгөний бодлогыг чангатгаж банкны тогтолцооны эрүүл тогтвортой нөхцлийг хангахад анхаарлаа төвлөрүүлэх шаардлагатай.

Сүүлийн үеийн мөнгөний үзүүлэлтүүд сул задгай байсан мөнгөний бодлогыг аажим чангатгасныг харуулж байна.

Төв Банкнаас арилжааны банкуудад олгосон зээл



- ✓ Бодлогын дэмжлэгтэй зээлийн өсөлтийг аажим багасгаж байгаа нь цаг хугацаа өнгөрөх тусам инфляцийг бууруулахад тусална.
- ✓ Мөнгөний бодлогыг чангатгах нь дотоодын мөнгөн тэмдэгтийн үнэ цэнэд үзүүлэх дарамтыг хөнгөвчлөхөд тусална.
- ✓ Банкны актив хөрөнгө суларч байгааг харгалзан банкны хяналтыг бэхжүүлэх шаардлагатай.
- ✓ Бодлогын дэмжлэгтэй зээлийн талаарх оновчтой зохицуулалтын хэрэгжилт сул байгааг хэвийн болгох шаардлагатай.
- ✓ Валютын ханшийн уян хатан дэглэмийг хадгалах шаардлагатай.
- ✓ Валютын ханшийн хөдөлгөөн нь эдийн засгийн тэнцвэргүй байдал их байгаа үед эдийн засгийн гол өөрчлөлт хийх механизмын нэг болдог.

Төсвийн Тогтвортой Байдлын тухай хуулийн дагуу төсвийн бодлого нь оновчтой арга замыг сэргээн хэрэгжүүлэх шаардлагатай.

Өнөөдрийн чиг хандлагаар, төсвийн алдагдал 2014 онд ДНБ-ний 10% -д хүрэхээр байна.

Төсвийн болон төсвийн гадуурх алдагдал (ДНБ-д эзлэх хувиар)



- ✓ Төсвөөс гадуурх зардлын улмаас төсвийн алдагдал их хэвээр үргэлжлэх нь импортыг хөөрөгдөж, эдийн засгийн тэнцвэргүй байдлыг хүндрүүлж нэмэгдүүлнэ.
- ✓ Төсвийн алдагдлын зэрэгцээ төсвийн хүчийг сулруулах нь олон улсын санхүүгийн зах зээлд улс орны зээлжих нөхцөлд сөргөөр нөлөөлж болзошгүй.
- ✓ Хэт их зардлыг танаж, ТТБТХ-ийг дагаж мөрдөх талаар улс төрийн харилцан ойлголцолд хүрэх нь чухал.
- ✓ Ашигт малтмалаас олох орлогыг хэрхэн үр дүнтэй захиран зарцуулж удирдах талаар бодох цаг нь болжээ.
- ✓ Баялагийн сангийн сайн тогтолцоо бий болгох нь хожим бороотой өдөр зарцуулах, хойч үедээ хадгалж үлдэхэд туслах хэрэгсэл болж болох юм.